

Living the Lotus 2

Buddhism in Everyday Life

2026
VOL. 245



2023 оноос тэргүүнээр ажилласан Мори тэргүүн үүргээ өгч, ОУХ-ын дарга асан Акагава тэргүүний үүргийг хүлээн авав.

РКК, Бангладеш салбарын тэргүүний үүрэг солилцох ёслол
“Талархсан сэтгэлээр шинээр эхлэх нь”

Living the Lotus
Vol. 245 (2026.02)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа
Эхийг хянасан: Ш.Зоригмаа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, ОУХ
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Миязава Кэнжигээс суралцах нь –2 “Баруунтаа ядарсан эх байвал”

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Газраас хөөрөн гарч ирсэн бодисатва лугаа

“Усан бороонд ажрахгүй” хэмээн эхлэх Миязава Кэнжи гуайн шүлгийг хэн бүхэн мэдэх болов уу. Өнгөрсөн сарын дугаарт надад судар уншиж буй мэт сэтгэгдэл төрүүлдэг гэж хэлсэн тэр шүлгийг бүрэн эхээр нь орчин үеийн ойлгомжтой үг хэллэгээр хүргэж байна.

Усан бороонд ажрахгүй
Уугих салхинаас халшрахгүй
Өвлийн цасанд сөхрөхгүй
Зуны халуунаас халгахгүй
Өлчир чийрэг биетэй
Өчүүхэн ч шуналгүй
Үүрд уурсан хилэгнэхгүй
Үргэлжид дуугүй инээмсэглэдэг
Бор будаа өдөрт дөрвөн аяга
Буурцагны шөл бага шиг ногоонд цадаж
Бусдын дараа өөрийгөө тавьдаг
Бүхэнд гярхай бас сонор соргог
Буцаад хожим үл мартах
Нарс модны сүүдрээр гэр хийж
Навч сүрлээр саравч хийх ч
Зүүн айлын хүү өвдвөл гүйн очиж асардаг
Баруунтаа ядарсан эх байвал будаа юуг нь дөхүүлэн өгдөг
Урд айлын хүн эцсийн мөчтэйгөө тулгарвал
Уйлаад яах вэ, эргээд төрнө гэж тайвшруулдаг
Хойно хэрүүл шуугиан гарвал
Хэнд ч хэрэггүй, больчих гээд зогсоодог
Хэт халуунд уйлан дуулж
Харин сэрүүн зун бол гэлдрэн алхах
Хэрэггүй амьтан гэж дуудуулж
Хэнд ч үл магтуулсан ч
Хээв нэг алхах
Тийм л нэгэн болохсон



Энэ шүлэгт Кэнжигийн сүсэг бишрэлээс улбаатай үнэн санаа тэр чигээрээ шингэсэн ба “гайхамшигтай” гэхээс өөр үг олдохгүй байна. Ялангуяа зүүн, баруун, урд, хойд дөрвөн зүг рүү очиж туслах хэсэг. Өвдсөн хүү байвал гүйн очиж, тариалангийн ажилдаа ядарсан эхэд тусалж, үхэлтэй нүүр тулж буй хүнд амь насны мөн чанарыг ухааруулж, хэрэлдэж муудалцах хүмүүсийг тайвшруулан эвлэрүүлнэ хэмээн бодитоор ямар сайн үйл хийхээ бичсэн байна. Хүмүүсийн зовлон, сэтгэлийн шаналалыг ойлгож, ямар ч байсан очиж өөрийн чадах зүйлээ хийж туслах нь сав ертөнцийн бодисатва хүний үүрэг гэдгийг энэ шүлэгт онцгойлон сануулсан нь мэдрэгдэнэ.

Тэрээр дэвтэртээ тус шүлгийн дараа Намо мёо хоо рэн гэ кёо тарнийн хоёр талд Олон Эрдэнэт түүнчлэн ирсэн, Шагжамүни бурхан, түүний дараа Дээд үйл, Хязгааргүй үйл, Ариун үйл, Амирлангуй үйл хэмээх дөрвөн бодисатвагийн нэрийг бичсэн Лянхуа судрын хот мандал зургийг дүрслэн буулгасан байдаг. Эдгээр дөрвөн бодисатва бол Бурханы хүсэл залбиралыг үйлдлээрээ хэрэгжүүлэн хамаг амьтныг амьдралын бодит зовлонгоос аврах газар доороос хөөрөн гарч ирсэн бодисадва нарын ахлагч нар юм. Би яаж тусалж чадах вэ гэж бодож, бусдын төлөө санаа тавих энэ чанараас бид олон зүйлийг ойлгож ухаарах хэрэгтэй.

Гярхай бас сонор соргог

Тус шүлгийн “бусдын дараа өөрийгөө тавьдаг гярхай бас сонор соргог” гэдэг хэсгийг унших тоолонд манай нийгэмлэгийн дүүргийн болон хэсгийн ахлагчаас авхуулаад гишүүд бүгдээрээ үүнийг мэдээжийн юм шиг л үргэлж хийдэг байх гэж бодогддог юм.

Өөрийнхөө үзэл бодлыг тулгалгүй, нөгөө хүнийхээ бурханлаг чанарт итгэж, зовж шаналж байгаа зүйлийг нь чих тавин сонсох. Энэ бол тухайн хүний зовлон шаналалаас ангижрах арга замыг хайж олох чухал хором мөч, гайхамшигтай бодисатвагийн үйл билээ. Ярьж буй хүн нь сонсож буй хүний халуун дулаан сэтгэлийг мэдэрч, гомдол цөхрөл, уй гашуу, зовлон бэрхшээлээ ярих явцдаа өөрийг нь зовоож байгаа зүйл, түүний шалтгаан нь юу болохыг өөрөө ухаарч, сэтгэл хөнгөрөн асуудлыг шийдэх гарцыг олдог.

Би дээр үед дотоодын дайнаас улбаатай үндэстэн хоорондын мөргөлдөөн ихтэй газар очиж байсан юм. Тэр улсын шашны төлөөлөгчидтэй уулзах үед Кэнжи гуайн шүлгийг мэддэг байсан болоод ч тэр үү, тэдний яриаг сайтар сонссон юм. Эхэндээ хэлэлцээр хийхэд ч хэцүү уур амьсгалтай байсан боловч аажмаар үг солилцож эхэлсэн. Одоо бодоход санаа бодлоо илэн далангуй хэлж ярилцах явцад дотор орших бурхан нь “хэрүүл тэмцэл хийх утгагүй” гэдгийг анзаарч ухаарсан биз ээ.

Дэлхий ертөнцийг харахаар зовж шаналж буй хүн тоо томшгүй их байгаа боловч бидний хийж чадах зүйл өчүүхэн. Ямар нэгэн байдлаар туслах юмсан гэж бодох ч, нээрэн л юу ч хийж чадахгүй “олиггүй амьтан” билээ бид. Хэдий тийм ч гэсэн томоор харах юм бол хүмүүст алга хавсран мөргөх сэтгэлээр хандаж, эелдэг дулаан харилцах гэсэн өдөр тутмын жижигхэн үйлдэл нь дэлхий ертөнцийн асуудлыг шийдэх хамгийн үндсэн зүйл гэдгийг марталгүй, өдөр бүрийг үр бүтээлтэй өнгөрөөх чухал. Кэнжи гуай үүнийг л бидэнд сургасан гэж бодож байна.

«Косей» сэтгүүл, 2-р сарын дугаараас



Ялгаатай зүйлсийн доторх ижил зүйл

Маэда Такаши

*Шри-Ланка салбар дээр сургаал
түгээж байгаа нь, 2025.12.20*



Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Өнгөрсөн жилийн сүүлээр би Бангладеш, Шри-Ланка салбараар зочилж, салбарын тэргүүн солигдог ёслолд оролцсон. Адилхан Зүүн Өмнөд Азийн улсууд боловч хэл соёл, хувцаслалт, идэж уух юм, амьдралын хэв маяг тэс өөр байсан. Харин яг адилхан зүйл нь халуун дулаан, сайхан сэтгэлээр харилцах гишүүд байсан билээ.

Тэнд байхад үүр цайх анир чимээгүй агшинд салхины чимээ, шувуудын жиргээн сонсогдсон. Нүдээ анихаар яг одоо хаана байгаагаа мэдэхгүй орчноос тасрах гайхамшигтай мэдрэмж төрсөн. Нүдээ нээхээр янз янзын зүйл харагдах боловч нүдээ аниад байгаль дэлхийтэй нэгэн бүхэл болох үед хаана ч байсан адилхан дэлхийн бөмбөрцөг дээр амьдарч байгаа гэдгээ хүчтэй мэдэрсэн. Тэр мөчид уулзаж учирсан гишүүд дэлхийн өнцөг булан бүрт сургаал түгээж байгаа газраас хөөрөн гарч ирсэн бодисатва болж харагдсан билээ.

Энэ сард Нивано ерөнхийлөгч Миязава Кэнжигийн “Бороонд ч ажрахгүй” шүлгээр дамжуулан би юу хийж чадах вэ гэж өөрөөсөө асуун бусдын төлөө зүтгэх газраас хөөрөн гарч ирсэн бодисатва хүний талаар сургасан байна.

Бид бүхэн бурхны сургаалыг хэрэгжүүлснээр олон хүнд сэтгэлийн тус дэм өгч чадна. Бид өөр өөр бие, зан чанар, хүсэл сонирхолтой боловч чухам тийм болохоор л олон янзын хүмүүст тусалж чадах юм.

Өөр өөрийнхөө онцлог чанарын дагуу өдөр тутамдаа жижигхэн ч гэсэн зөв сайхан үйл хийх нь дэлхийн энх тайвантай холбогдоно гэдгийг санаж, энэ сард ч гэсэн өөдрөг гэгээлэг хичээж шамдацгаа.




Шри-Ланка салбарын тэргүүн томилох ёслолын дараах дурсгалын зураг

Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about
local Dharma centers



facebook



X



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp